



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН САЙД

Засгийн газрын III байр, Бага тойруу 44,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: 26 22 27, Факс: (976-51) 26 37 27,
Цахим шуудан: letter@moe.gov.mn,
Цахим хуудас: www.moe.gov.mn

2025.12.12 № 01/6192

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Б.ХЭРЛЭН ТАНАА

Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.11-д заасан “Зайн болон цахим сургалт зохион байгуулах, эзэмшсэн боловсролыг үнэлэх, дүйцүүлэх журам”, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7-д заасан “Гэрийн сургалт зохион байгуулах түүнд хяналт тавих журам” батлах талаар ирүүлсэн асуултын хариултыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 3 хуудастай..



П.НАРАНБАЯР

ATA12937 9116621 9024070582

14255 2026

Боловсролын сайдын
2025 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн
1/612 тоот албан бичгийн хавсралт



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.ХЭРЛЭНГИЙН АСУУЛТЫН ХАРИУЛТ**

1.Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.11-д “Зайн болон цахим сургалт зохион байгуулах, эзэмшсэн боловсролыг үнэлэх, дүйцүүлэх журам”-ыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасны дагуу журмын төслийг боловсруулж, яамны холбогдох нэгж, албан тушаалтнуудаас саналыг авч тусгах үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Журмын төслийг бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын суралцагчдад орон зай, цаг хугацаанаас үл хамааран суралцах, насан туршдаа суралцах тэгш боломжийг бүрдүүлэх нээлттэй боломж бий болгох, байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлийн үед сургалтын үйл ажиллагааг тасалдалгүй зохион байгуулах, суралцагчдын суралцах үйл явцыг илүү үр дүнтэй, сонирхолтой, хүртээмжтэй болгох, цахим ур чадварыг нэмэгдүүлэх, цахим хуваагдлыг бууруулахад чиглүүлэн сайжруулж, батлан хэрэгжүүлэхийг зорьж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.4. дэх “Цахимжсан боловсрол” зорилтын хүрээнд 2.2.4.3.-т “Иргэдэд насан туршдаа суралцах тэгш боломжийг бүрдүүлж, нээлттэй боловсролын тогтолцоог хөгжүүлж, хүн бүрд орон зай, цаг хугацаанаас үл хамааран суралцах, боловсрол эзэмших тэгш хүртээмжтэй сургалтын контент, мэдээллийн системийг нэвтрүүлж, ур чадвар, чадамжийг дэмжсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж, гэрчилгээ олгох, микро кредитийн сургалтыг холбогдох талуудтай хамтран хэрэгжүүлнэ” гэж, “Цахим сургалтын байгууллагыг байгуулж, суралцагчийн эзэмшсэн мэдлэг, ур чадварыг албан боловсролын сургалтад дүйцүүлэн дэвшин суралцаж, төгсөх боломжийг бүрдүүлнэ” гэж тус тус заасан.

Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн “Ерөнхий боловсролын цахим сургууль байгуулах тухай” 130 дугаар тогтоолоор төрийн өмчит ерөнхий боловсролын цахим сургуулийг байгуулсан. Энэхүү цахим сургуулийн үйл ажиллагааг эхлүүлэх, тус цахим сургуулиар дамжуулан хилийн чанад болон алслагдсан орон нутгийн, ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад ерөнхий боловсролын үйлчилгээнд зайнаас, цахим хэлбэрээр ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдах, ахлах ангийн сонгон судлах хичээлийг зайнаас судлах зэрэг боломжийг бүрдүүлэхээр зорьж байна.

Ерөнхий боловсролын цахим сургуулийг түшиглэн дараах чиглэлийн сургалтуудыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургуулийн багшийн хомсдолтой, сонгон судлах хичээлийн бүлэг бүрдээгүй анги, хичээлүүд;
- Олон улсын мэдээллийн технологийн хөтөлбөрийн сургалт;
- Сургуулийн гадна байгаа хүүхэд, залуучуудад ерөнхий боловсрол нөхөн ээмшүүлэх;
- Танхимын сургалтад тогтмол хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг боловсролын үйлчилгээнд хамруулах;
- Гадаадад амьдарч буй Монгол Улсын иргэдийн хүүхдүүдэд бага боловсрол эзэмшүүлэх болон Монгол, хэл соёлын хөтөлбөрт хамруулах;
- Гадаад улс орон болон сүм хийдэд шавилан сууж буй ламхай хүүхэд, эрх нь хязгаарлагдсан хүүхдүүд;
- Багш нарын цахим ур чадвар, мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт.

Боловсролын цахим шилжилтийн хүрээнд одоогийн байдлаар ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад зориулан 11,265 ээлжит хичээлийн контент бүхий цахим санг бүрдүүлээд байгаагаас заавал судлах хичээлийн 9,478, сонгон судлах 1,565 хичээл, сурах бичиг 147, теле хичээл 4,024, интерактив контент 230, интерактив дасгал ажлын хуудас 3,500, виртуал лаборатори 805, цахим ур чадвар олгох 413 хичээл нийт 20,000 гаруй контент <https://medle.mn/> платформд байршсан байна.

Зайн болон цахим сургалт зохион байгуулах, техник, технологи, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/67 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн багшийн мэдээлэл харилцаа, холбооны технологийн цогц чадамжийн нийтлэг шаардлага”, Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын 2021 оны А/193 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтад ашиглах цахим сурах бичигт тавих шаардлага”, “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтад ашиглах сургалтын нээлттэй материал, сургалтын интерактив контентэд тавих шаардлага”, Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын 2022 оны А/465 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”, Боловсролын сайдын 2024 оны А/465 дугаар тушаалаар “Боловсролын цахим сан бүрдүүлэх, ажиллуулах журам” тус тус батлан хэрэгжүүлж байна.

“Боловсролын дэлхийн түншлэл” байгууллагын буцалтгүй тусламжаар Боловсролын яам, Японы Хүүхдийг Ивээх Сан хамтран хэрэгжүүлж буй “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” “Хосолсон сургалт” гуравдугаар бүрэлдэхүүний хүрээнд ерөнхий боловсролын сургуульд зайн болон цахим, хосолсон сургалт зохион байгуулах туршилтыг 2024-2025 оны хичээлийн жилд хот хөдөөгийн ерөнхий боловсролын 85

сургуулийг хамруулан зохион байгуулсан. Мөн тус төслийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн цахим, зайн сургалтын бэлэн байдлын үнэлгээ, багшийн бэлэн байдлын өөрийн үнэлгээний аргачлалыг тус тус боловсруулаад байна.

Дээрх төсөл хөтөлбөрийн үр дүн, боловсролын цахим шилжилтийн хүрээнд бий болгосон туршлага, цахим нөөцүүдийн ашиглалт, хэрэглээ, холбогдох эрх зүйн зохицуулалтуудыг "Зайн болон цахим сургалт зохион байгуулах, эзэмшсэн боловсролыг үнэлэх, дүйцүүлэх журам"-ын төсөлд тусган, уялдуулан боловсруулж байна.

2. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 22.7-д заасан "Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр бага боловсролыг гэрийн сургалтаар эзэмшүүлэх"-тэй холбоотой "Гэрийн сургалт зохион байгуулах, түүнд хяналт тавих журам"-ын төсөл боловсруулалтын шатанд байна.

Гэрийн сургалт зохион байгуулах нь олон улсад төдий л түгээмэл биш бөгөөд ихэнх улс оронд хязгаарлагдмал зохицуулалт үйлчилж байгаа нь нэг талаар хүүхдэд уян хатан зохицуулалт бүхий боловсролын үйлчилгээнд хамрагдах боломжийг олгох давуу талтай боловч нийгэмшлийн хувьд хязгаарлагдмал нөхцөлд орох, гэр бүлийн зүгээс илүү их анхаарал, дэмжлэг шаардах сул талыг бий болгодогтой холбоотой байна.

Иймд хилийн чанадад оршин сууж буй Монгол хүүхэд болон ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад бага боловсролыг гэрийн сургалтаар эзэмшүүлэхээр эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан тохиолдолд гэр бүлийн дэмжлэг, суралцах орчин нөхцөл бүрдүүлсэн байдал, хүүхдийн нийгэмшил, сэтгэл зүйн дэмжлэг авах боломж, аюулгүй байдал, сургууль завсардах эрсдэл бий болохоос урьдчилан сэргийлэх, гэрийн сургалт зохион байгуулалтад сургалтын байгууллагаас дэмжлэг үзүүлэх, үр дүнг хянаж, үнэлэх, баталгаажуулах зэрэгтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна. Мөн энэхүү албан бичгийн 1 дэх хэсэгт дурдсан зайн болон цахим сургалт зохион байгуулах журамтай энэхүү журмыг уялдуулах хэрэгцээ шаардлагатай юм.

Дээрх 2 журмын төсөлд Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, Нийслэлийн Боловсролын газрын удирдах ажилтан, ахлах шинжээч, ахлах мэргэжилтнүүд болон Ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, багш нарын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, санал авах үйл ажиллагааг зохион байгуулж байна. Эдгээр журмыг Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлд заасан санал авах үйл ажиллагаа, 65 дугаар зүйлд заасан дагуу улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх үйл ажиллагааг 2026 оны нэгдүгээр улиралд багтаан зохион байгуулахаар төлөвлөж байна.